



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/53

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, боловсруулах үйлдвэрүүдийг Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санд бүртгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх – Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Гантулга – Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэрлэл,
худалдаа үйлчилгээний асуудал
хариуцсан мэргэжилтэн

Х.Батцэцэг – Аймгийн Татварын хэлтсийн дарга

Б.Хоролсүрэн - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Н.Батчулуун – Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Д.Мөнхжаргал – Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнс,
худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Д.Эрдэнэдорж – Хүнс, хөдөө аж ахуйн газрын
үйлдвэрлэл, худалдаа
үйлчилгээний албаны дарга

2. Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй боловсруулах үйлдвэрүүдийн мэдээллийг нэгтгэн гаргаж www.industry4.nda.gov.mn цахим мэдээллийн системд 2021 оны 2 дугаар сард багтаан бүртгэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН